

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5.1 Төлбөрийн акт	23
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.АРМИЯ ТАНАА

2023.03.24 № 290
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Дүгнэлт-НДХ-3.20Нийгмийн даатгалын хэлтэс-ТА

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,357,324,435.77</u>	<u>10,356,466,062.62</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,360,772,416.25	7,346,322,810.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,360,772,416.25	7,346,322,810.21
3121	Төгрөг	7,360,772,416.25	7,346,322,810.21
31211	Төрийн сангийн харилцах	-	4,739,360.00
31213	Арилжааны банк дахь харилцах	7,360,772,416.25	7,341,583,450.21
33	АВЛАГА	3,986,822,854.32	3,001,245,536.41
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	703,792,089.11	982,514,328.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,280,603,383.21	2,014,044,653.21
335	Бусад авлага	2,427,382.00	4,686,555.00
3351	Байгууллагаас авах авлага	2,427,382.00	4,686,555.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,729,165.20	8,897,716.00
354	Хангамжийн материал	9,729,165.20	8,897,716.00
35410	Бичиг хэргийн материал	2,101,000.00	2,130,000.00
35420	Аж ахуйн материал	6,303,846.00	5,775,046.00
35470	Бусад хангамжийн материал	1,324,319.20	992,670.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>304,861,928.17</u>	<u>362,959,064.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	304,861,928.17	362,959,064.84
392	Биет хөрөнгө	295,066,928.17	353,164,064.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	249,767,990.00	249,767,990.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,301,579.09)	(31,068,772.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,000,000.00)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,474,009.38	150,636,643.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,319,642.30)	(39,392,360.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,593,340.00	53,789,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,147,189.82)	(39,568,776.23)
393	Биет бус хөрөнгө	9,795,000.00	9,795,000.00
39301	Програм хангамж	3,253,332.00	3,253,332.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,253,332.00)	(3,253,332.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,795,000.00	9,795,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,662,186,363.94</u>	<u>10,719,425,127.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>135,903,335.14</u>	<u>120,971,311.46</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	135,903,335.14	120,971,311.46
413	Өглөг	14,006,744.57	7,890,291.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	14,006,535.75	7,890,291.60
4136	Бусад өглөг	208.82	-
41361	Байгууллагад төлөх өглөг	208.82	-
414	Урьдчилж орсон орлого	121,896,590.57	113,081,019.86
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	121,896,590.57	113,081,019.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,526,283,028.80</u>	<u>10,598,453,816.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,526,283,028.80	10,598,453,816.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	183,680,602.83	183,680,602.83
512	Хуримтлагдсан үр дүн	11,295,089,990.72	10,367,260,777.92
51210	Өмнөх үеийн үр дүн	9,441,189,976.32	11,295,089,990.72
51220	Тайлант үеийн үр дүн	1,853,900,014.40	(927,829,212.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,512,435.25	47,512,435.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,662,186,363.94</u>	<u>10,719,425,127.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	73,352,797,583.85	96,441,507,732.66	
11	ТАТВАРЫН ОРЛОГО	31,161,434,381.71	32,439,298,199.86	
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	31,161,434,381.71	32,439,298,199.86	
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,536,246,144.35	22,376,871,939.81	
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,039,871,522.07	2,346,329,982.03	
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,112,184,103.40	1,269,876,461.20	
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	413,842,524.48	477,621,200.12	
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,059,290,087.41	5,968,598,616.70	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,514,966.14	55,726,106.80	
120	Нийтлэг татварын бус орлого	45,514,966.14	55,726,106.80	
120002	Хүүгийн орлого	9,627,295.64	43,683.97	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,751,778.50	13,532,948.83	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,305,978.50	13,402,948.83	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	445,800.00	130,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,100,000.00	24,582,700.00	
120009	Бусад орлого	7,035,892.00	17,566,774.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,145,848,236.00	63,946,483,426.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		-	12,734,339,520.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-	12,734,339,520.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00		11,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00		11,200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	41,528,022,936.00		50,445,622,606.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,528,022,936.00		50,445,622,606.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	617,540,300.00		755,321,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	617,540,300.00		748,524,000.00

210702	Дотоод албан томилолт	1,782,500.00	4,351,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,753,917.14	14,666,953.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,057,706.00	4,611,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,180.00	175,280.00
210807	Газрын төлбөр	39,180.00	32,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,668,054.34	6,935,130.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,510,796.80	2,412,755.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,270,589.94	32,458,563.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,285,000.00	1,900,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,985,589.94	30,558,563.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,851,884,829.37	96,707,929,847.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,300,427,114.00	86,306,313,433.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,292,933,114.00	86,175,883,966.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,494,000.00	7,584,867.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	122,844,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,551,457,715.37	10,401,616,414.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,551,457,715.37	10,401,616,414.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,853,472,024.40	(927,829,212.80)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	427,990.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	427,990.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	427,990.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,853,900,014.40	(927,829,212.80)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	72,665,197,365.85	97,353,609,586.86
11	ТАТВАРЫН ОРЛОГО	30,408,112,460.21	32,163,035,761.06
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	30,408,112,460.21	32,163,035,761.06
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,192,131,337.95	22,182,326,605.10
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,853,125,104.15	2,326,578,613.56
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	958,880,046.75	1,257,136,775.03
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	378,113,970.66	473,832,072.82
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,025,862,000.70	5,923,161,694.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,747,205.64	32,564,525.80
120	Нийтлэг татварын бус орлого	74,747,205.64	32,564,525.80
120002	Хүүгийн орлого	9,627,295.64	43,683.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,119,910.00	32,520,841.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,674,110.00	32,390,841.83
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	445,800.00	130,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,182,337,700.00	65,158,009,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	44,512,400.00	14,000,819,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	44,512,400.00	14,000,819,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00	11,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	11,200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	41,520,000,000.00	50,390,668,500.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,520,000,000.00	50,390,668,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	617,540,300.00	755,321,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	617,540,300.00	748,524,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	6,797,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	71,493,231,461.10	97,368,059,192.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,493,231,461.10	97,368,059,192.90

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	614,968,619.34	635,925,717.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448,211,254.00	479,291,358.65
210101	Үндсэн цалин	317,378,999.00	337,292,925.23
210102	Нэмэгдэл	104,550,655.00	76,996,823.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,521,600.00	24,398,392.01
210104	Урамшуулал	5,760,000.00	40,603,217.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,412,193.00	60,053,551.73
210201	Тэтгэврийн даатгал	40,415,396.34	41,415,105.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,497,738.86	4,727,258.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,598,191.09	3,758,286.74
210204	Ажилгүйдлийн даатгал	899,547.77	910,104.85
210205	Эрүүл мэндийн даатгал	9,001,318.94	9,242,795.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,141,379.00	22,193,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,856,705.00	1,866,400.00
210302	Түлш, халаалт	18,000,000.00	18,992,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,284,674.00	1,335,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,964,207.00	21,277,700.00
210401	Бичиг хэрэг	7,000,000.00	6,052,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,476,500.00	9,780,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,987,850.00	2,879,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,499,857.00	2,375,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,655,770.00	32,593,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,466,900.00	13,593,500.00
210604	Урсгал засвар	13,188,870.00	19,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,782,500.00	4,351,800.00
210702	Дотоод албан томилолт	1,782,500.00	4,351,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,516,316.34	14,264,198.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,057,706.00	6,621,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,180.00	175,280.00
210807	Газрын төлбөр	39,180.00	32,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,668,054.34	6,935,130.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,273,196.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,285,000.00	1,900,208.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	208.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,285,000.00	1,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,878,262,841.76	96,732,133,475.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,327,011,626.39	86,330,517,061.15
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,310,735,914.00	86,172,246,766.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,494,000.00	7,584,867.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,781,712.39	27,840,828.15
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	122,844,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,551,251,215.37	10,401,616,414.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,551,251,215.37	10,401,616,414.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,171,965,904.75</u>	<u>(14,449,606.04)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,171,965,904.75	(14,449,606.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,188,806,511.50	7,360,772,416.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,360,772,416.25	7,346,322,810.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	9,408,962,474.32	9,640,155,512.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	32,227,502.00	32,227,502.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	9,441,189,976.32	9,672,383,014.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,853,900,014.40	1,853,900,014.40
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	11,295,089,990.72	11,526,283,028.80
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	11,295,089,990.72	11,526,283,028.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	11,295,089,990.72	11,526,283,028.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-927,829,212.80	-927,829,212.80
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,680,602.83	47,512,435.25	10,367,260,777.92	10,598,453,816.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,153,481,800.00	86,927,401,741.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,153,481,800.00	86,927,401,741.38

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635,177,600.00	624,725,508.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	483,316,200.00	479,291,358.65
210101	Үндсэн цалин	337,298,500.00	337,292,925.23
210102	Нэмэгдэл	77,000,000.00	76,996,823.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,984,000.00	24,398,392.01
210104	Урамшуулал	41,033,700.00	40,603,217.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,852,100.00	60,053,551.73
210201	Тэтгэврийн даатгал	43,219,400.00	41,415,105.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,908,100.00	4,727,258.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,926,600.00	3,758,286.74
210204	Ажилгүйдлийн даатгал	981,600.00	910,104.85
210205	Эрүүл мэндийн даатгал	9,816,400.00	9,242,795.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,193,400.00	22,193,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,866,400.00	1,866,400.00
210302	Түлш, халаалт	18,992,000.00	18,992,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,335,000.00	1,335,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,277,700.00	21,277,700.00
210401	Бичиг хэрэг	6,052,700.00	6,052,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,780,900.00	9,780,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,879,100.00	2,879,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,000.00	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.00	2,375,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,405,400.00	21,393,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,405,400.00	2,393,500.00
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,351,800.00	4,351,800.00
210702	Дотоод албан томилолт	4,351,800.00	4,351,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,881,000.00	14,264,198.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,622,100.00	6,621,780.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	175,280.00
210807	Газрын төлбөр	50,000.00	32,008.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,508,900.00	6,935,130.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,518,304,200.00	86,302,676,233.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,518,304,200.00	86,302,676,233.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,387,746,600.00	86,172,246,766.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,713,000.00	7,584,867.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	122,844,600.00	122,844,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,153,481,800.00	40,276,609,971.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,000,819,500.00	14,000,819,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	14,000,819,500.00	14,000,819,500.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,152,662,300.00	26,246,715,050.48
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	73,145,865,000.00	26,239,917,750.48
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,797,300.00	6,797,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	29,075,421.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,945,421.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	130,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,360,772,416.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,346,322,810.21
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	35
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	30	29
620003	Үйлчлэх ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36.00	35.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	31	26
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,200,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,200,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах, улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь “Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” эрхэм зорилготой ба “2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болох” хэтийн зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэх бодлого баримтлан ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагуудад мөрдөж байгаа бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд тус байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/64 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” –ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 942.8 сая төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,360,772.42	7,346,322.81	(14,449.61)
Авлага	3,986,822.85	3,001,245.54	(985,577.32)
Бараа материал	9,729.17	8,897.72	(831.45)
Үндсэн хөрөнгө	304,861.93	362,959.06	58,097.14
Нийт хөрөнгө	11,662,186.36	10,719,425.13	(942,761.24)
Өр төлбөр	135,903.34	120,971.31	(14,932.02)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,526,283.03	10,598,453.82	(927,829.21)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,662,186.36	10,719,425.13	(942,761.24)

Эх сурвалж: Санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхнээс 14.4 сая, бараа материалын данс 0.8 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 985.6 сая төгрөгөөр буурсан төлбөртэй үйлчилгээний авлага 278.7 сая төгрөгөөр нэмэгдэж, татаас, санхүүжилтийн авлага 1,266.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 58.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үнэ төлбөргүй 88.7 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 30.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд -927.8 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 927.8 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд улсын төсөв болон нийгмийн даатгалын сангаас санхүүжих эх үүсвэрийг 21,948.5 сая, зарлагыг 79,147.2 сая, улсын төсвөөс авах үйл ажиллагааны төсвийг 822.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орлого эх үүсвэрийг 3,146.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 25,095.4 сая төгрөгөөр, зардлыг 5,775.0 сая төгрөгөөр бууруулж 73,372.3 сая төгрөгөөр баталсан байна. Үйл ажиллагааны төсвийг 76.5 сая төгрөгөөр бууруулж 746.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвийг буюу эх үүсвэрийг анх баталсан төсвөөс 24.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 25,120.1 сая төгрөгөөр, зардлыг 13,026.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 86,398.2 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Үйл ажиллагааны төсвийг 8.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 755.3 сая төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр үйл ажиллагааны төсвийг 755.3 сая төгрөгөөр тодотгож баталсан ба 748.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 6.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр байгууллагын үйл ажиллагаанд нийгмийн даатгалын сангаас 748.5 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 6.8 сая төгрөгийн буюу нийт 755.3 сая төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангаас авсан санхүүжилтээс 7.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжид улсын төсвөөс 14000.0 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 91,572.7 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 28.9 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж ажилласан байна. Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжид 86,172.2 сая, банк, санхүүгийн үйлчилгээний хураамжид 6.8 сая, нийт 86,179.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 748.3 сая төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 7.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нийгмийн даатгал	755,321.30	748,314.80	-7,006.50	99.1%
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	571,244.70	566,321.20	-4,923.50	99.1%
1.2	Эрүүл мэндийн даатгалын сангаас	6,797.30	6,797.30	0.00	
1.3	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил	17,010.00	16,727.30	-282.70	98.3%
1.4	Мэдээлэл сурталчилгааны зардал	2,666.70	2,666.70	0.00	100.0%
1.5	Өмгөлөөл, хуулийн зөвлөхийн хөлс	400.00	400.00	0.00	100.0%
1.6	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	26,645.00	24,972.80	-1,672.20	93.7%
1.7	Ажил олгогчоос олгох тэтгэмж	122,844.60	122,844.60	0.00	100.0%
1.8	Бусад тусламж дэмжлэг	5,413.00	5,354.90	-58.10	98.9%
1.9	Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.00	2,230.00	-70.00	97.0%
2	Нийгмийн даатгалын сан	86,387,746.6	86,172,246.7	-215.5	99.8%
2.1	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,387,746.6	86,172,246.7	-215.5	99.8%
	Дүн	87143067.9	86920561.5	-222.5	99.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнд 2022 онд 11.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, багаж, техник хэрэгсэлд 11.2 сая төгрөгийг дарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 53 дугаар албан бичгээр 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 71,499.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 714.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг 7.0 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 4.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2.8 сая, эд хошгил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 0.1 сая, тэтгэмж, урамшууллын зардлыг 0.1 сая, нийт 7.0 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэх, 8 дугаар зүйлийн 8.2-т “энэ хуулийн 3.1.1.-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдсэн ба алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

